



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/197

Есөнбулаг

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх
дархлаажуулалтын ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйл 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 07-ны А/68 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг аймгийн хэмжээнд 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.

2. Мал амьтныг халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх ажилд малчид, мал бүхий иргэд, аж ахуйн нэгж, орон нутгийн төр, захиргааны байгууллагуудыг татан оролцуулж, ажиллах хүч, хашаа хороо, тээврийн хэрэгслээр хангаж, тогтоосон хугацаанд шуурхай зохион байгуулж ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээнд шаардагдах биобэлдмэл, вакцин, эм урвалжийг хугацаанд нь татан авч хуваарилах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавьж, ажлын явцыг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор, үр дүнг 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хурлаар тайлагнахыг Мал эмнэлгийн газар (Р.Бүрэнбаясах)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, аймгийн удирдлагыг мэдээллээр хангаж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

